

ЭГЗЭГТЭЙ ЦАГ МӨЧИД ХҮНИЙ ЗҮРХ СЭТГЭЛ ТАНИГДДАГ

“Дафагийн шавь” хэмээх нэр бол хамгаас нандин юм. Тэр хүн орчлон ертөнцийн хамгийн дээд Агуу хууль дагуу бясалгадаг, амь бодийг аврахад багшдаа туслахыг амьдралынхаа үндсэн зорилго гэж үздэг. Ямар ч нөхцөл байдлаас үл хамааран өөрийгөө сайн бясалгах, Дафа-г сахин хамгаалахыг эн тэргүүнд тавьдаг.

Тиймээс ямар ч нөхцөл байдалд бясалгагч хүний шалгуур дагуу байж, Фа-г эн тэргүүнд тавьж, бүх зүйлийг Фа дагуу цэгнэдэг байх ёстой. Фа цэвэрлэгээ болон амь бодийг аврах энэ түүхт чухал цаг үеийн эцсийн мөчид гарч буй бүх асуудалд бясалгагч хүний байр сууринаас хандах, Фа-г бүхнээс түрүүнд тавих, мөн гол бодох, хийвэл зохих зүйл бол Дафа-гийн сурагчдын төслүүдийг хамгаалах, тэдгээр нь амь бодийг аврахад сайн нөлөө үзүүлэхэд анхаарах явдал юм. Энэ эгзэгтэй мөчид гаргасан аливаа хувиа хичээсэн бодол үйлдэл нь бүгд хорон муу нөлөө үзүүлнэ. Бясалгагчдын төслийг “хэн” дотроос нь будлиантуулж байна вэ? Бурхад үүнийг харж байна, хуучин хүчнийхэн харж байна, улаан чөтгөр ч бас харж байна.

Дафа бол орчлон ертөнцийн хууль, хэн ч үүнийг эвдэж чадахгүй. Дафа энэ орчлонгийн хүмүүсийг аварч байна! хүний зүрх сэтгэл ямар байх нь чухал! Хэн ямар албан тушаалд байх нь чухал биш. Ялангуяа ийм нөхцөл байдалд хүн бүр ижил сэтгэл санаатай байх хэрэгтэй, Фа-г нэн тэргүүнд тавьж, өөрсдийгөө бясалгагч хүний жишигт барьж, амь бодийг аврах төсөлд хор хөнөөл учруулахгүй байхад анхаарах хэрэгтэй. Бэрхшээлийг даван туулж чаддаг байх нь бясалгагч хүнд байх ёстой үзүүлэлт юм. Энэ бол Вэйдэ (Агуу буян). Учир нь энэ бол чиний давах ёстой сорилт.

Энэ нь сүүлчийн цаг хугацаанд бясалгадаггүй, хуурамчаар бясалгадаг мөн чин сэтгэлээсээ бясалгадаггүй хүмүүсийг илчлэх явдал гэж та нар бодохгүй байна уу? Эцсийн өдрүүдэд дэлхийн хүмүүсийг аврахын зэрэгцээ бас Дафа-гийнхны дотор цэвэрлэгээ явагдаж байна гэж та нар бодохгүй байна уу?

Хэн ч Дафа-гийн орчинд замбараагүй байдал үүсгэж болохгүй, энэ бол Фа-г үймүүлж буй хэрэг! Хэн үүнийг хийв? Үүнийгээ зас! Маш бага хугацаа үлдлээ!

Багш Ли Хонжи
2025 оны хоёрдугаар сарын 2